



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №24



2019 оны 8-р сарын 05-09

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **883** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 104(11.8%) галзуугийн эрсдэлд өртсөн, 758(85.8%) хачигт халдвар, 6(0.7%) боом, 7(0.8%) тарваган тахал, 2(0.2%) хумхаа, 1(0.1%) ям, 2(0.2%) денги, 3(0.3%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 104 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6%-иар нэмэгдсэн байна. Эпидемиологийн 31 дүгээр долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (39.4%), чононд (18.3%), эзэнгүй нохойд (14.4%), үнэгэнд (8.7%), үхэрт (7.7%), мануулд (2.9%), мууранд (1.9%), тэмээнд (1.0%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 758 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24.8%-иар буурсан байна. Эпидемиологийн 31 дүгээр долоо хоногтой харьцуулахад 18 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



2019 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар ХР-ын 612 сэжигтэй тохиолдлын 118 (19.3), ХБ-ын 69 сэжигтэй тохиолдлын 14 (20.3%), ХЭ-ын 77 сэжигтэй тохиолдол 16 (20.7%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан байна.

1.3 Боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

2019 оны 8 дугаар сарын 03-нд Дорнод аймгийн Баяндун сумаас боомын хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол мэдээлэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн.

1.5 Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар нийслэлийн 4 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 47 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Энэ долоо хоногт нийслэлийн БГД, СХД-ээс ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага) дуудлаганд үйлчилсэн. Сорьц материалыг шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мэрэгч амьтны дуудлага:


Завхан аймгийн Цагаанчулуут сумын Дэлгэр багийн “Тайж” гэдэг газар 1 удаа амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Эх сурвалж: Завхан аймгийн ЗӨСТ


Олон улсад:

Эбола вирус халдвар:

2019 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй тохиолдол 2713 тохиолдол бүртгэгдсэнээс 1823 (67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1527 (56%) нь эмэгтэйчүүд, 773 (29%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Хүснэгт 1. Эпидемиологийн долоо хоногоор



Зураг 1. Эбола вирус халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

MERS-CoV-ийн халдвар:

Саудын Араб улсын ЭМЯ-ны 28 дугаар долоо хоногийн эргэн мэдээллээр MERS-CoV-ийн халдварын сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. Нажран дүүрэгт амьдардаг 74 настай эрэгтэй, тэмээтэй хавьтал болсон өгүүлэмжгүй байна.



Эх сурвалж: Promed

Африкийн гахайн мялзан өвчин:

БНХАУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 7 дугаар сарын 29-нд Хубэй мужид африкийн гахайн мялзан өвчний дэгдэлт бүртгэгдэж 3 гахай өвчилж үхэн, 29 гахайг устгасан байна.

Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Хонины цэцэг өвчин:

ОХУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 8 дугаар сарын 05-нд Московская тосгоны фермд хонины цэцэг өвчин бүртгэгдэж 11 хонь өртөмхий байснаас 4 хонь өвчилсөн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	- Унгар улс - Ворсод-Авуж-Земплэйн	2019.08.06	2019.07.30	Ойд	1 зэрлэг гахай	1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	- Польш улс - Ливелски тосгон	2019.08.06	2019.08.05	Ферм	8 гахай	1 гахай	7 гахай
ДМАЭМБ	- Словак улс - Кошице тосгон	2019.08.07	2019.08.05	Тодорхойгүй	1 гахай	1 гахай	

Эх сурвалж: ДМАЭМБ